



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 43

Пионер толгой

"Эрүүл бэлчээр-Эрсдэлгүй малчны хот"
уриатай сэг зэм устгал, халдваргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.4 Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/206 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг, зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал эмнэлгийн тасаг (Э.Хас-Очир), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201271